# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 11 сарын 11 өдөр Дугаар 19/04 Арвайхээр сум

## Үндсэн хөрөнгө залруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн "Журам батлах тухай" 24/02 дугаар тогтоолын 2.1.2-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын газрын 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 317/А1571147/ӨВА-2026/05-14-ШТА-НА дугаартай албан шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн "Үндсэн хөрөнгөнд эзэмшигч тогтоож бүртгэх тухай" 12/01 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан жагсаалтын 25 дугаарт бичигдсэн Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн дээврийн засварын гэрээний дүн 65,379 (жаран таван мянга гурван зуун далан ес) төгрөгөөр үндсэн хөрөнгөнд илүү бүртгэгдсэнийг хасч, 88,784,621 (наян найман сая долоон зуун наян дөрвөн мянга зургаан зуун хорин нэг) төгрөгөөр залруулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу залруулж бүртгэхийг Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Ц.Лүндээжанцанд даалгасугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

ДАРГА Т.НАРАНГАРАВ